

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль², энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлогыг төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0 185.0

¹ Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

² Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

2	Монгол Улсын Их Хурлын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0 100.0
3	Монгол Улсын Ерөнхий сайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	106,372.5 101,600.0 4,772.5
4	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0 510.0
5	Монгол Улсын Ерөнхий аудитор Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	831.3 831.3
6	Төрийн албаны зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	200.0 200.0
7	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,000.0 4,000.0
8	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,388.3 2,388.3
9	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	20,954.3 20,954.3
10	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	115.9 115.9
11	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	300.0 300.0
12	Гадаад харилцааны сайд Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	16,100.0 13,000.0 3,100.0
13	Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	21,278,121.4 12,731,009.6 608,889.9 7,872,540.0 248,209.1 417,000.0 9,362.6
14	Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Шүүх шинжилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	81,156.8 45,730.0 2,370.0 300.0 1,052.5 31,704.4
15	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ашигт малтмал, газрын тосны газар Үндэсний геологийн алба Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	412,848.1 407,301.1 120.0 5,427.0
16	Батлан хамгаалахын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	43,187.2 43,187.2
17	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,226.9 2,226.9

18	Боловсролын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,534.8 5,534.8
19	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	304.0 304.0
20	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	69,153.9 1,000.0 3,035.1 65,118.8
21	Зам, тээврийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн яам Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	110,656.0 80,000.0 300.0 30,356.0
22	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	49,173.6 49,173.6
23	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,663.3 8,663.3
24	Эрүүл мэндийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	7,945.3 7,945.3

4 дүгээр зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 22,837,920.9 сая төгрөг байна.

5 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөрийг төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	387,133.9
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	20,600.7
3	Боловсролын сайд	30,000.0
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	62,310.3

6 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсвийг зарцуулна:

6.1.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	37,603.0 36,603.0 1,000.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	170,302.4 161,742.4 8,560.0

3	Монгол Улсын Ерөнхий сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	626,974.8 367,312.1 259,662.7
4	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Урсгал зардал	5,488.7 5,488.7
5	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Урсгал зардал Хөрөнгийн зардал	31,861.6 27,233.4 4,628.2
6	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	329,796.4 266,811.9 62,984.5
7	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	14,896.9 12,184.9 2,712.0
8	Улсын ерөнхий прокурор Урсгал зардал Хөрөнгийн зардал	157,568.5 127,719.4 29,849.1
9	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Урсгал зардал	22,569.7 22,569.7
10	Монгол Улсын Ерөнхий аудитор Урсгал зардал Хөрөнгийн зардал	54,388.4 53,209.6 1,178.8
11	Авлигатай тэмцэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	56,946.0 54,585.1 2,360.9
12	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	21,703.7 21,453.7 250.0
13	Төрийн албаны зөвлөлийн дарга Урсгал зардал	19,420.4 19,420.4
14	Үндэсний статистикийн хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	34,392.7 32,392.7 2,000.0
15	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Урсгал зардал	15,750.3 15,750.3
16	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Урсгал зардал	1,310.2 1,310.2
17	Шүүхийн сахилгын хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	6,171.9 5,871.9 300.0
18	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	276,031.2 117,454.2 158,577.0
19	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	388,505.5 324,292.9 64,212.6
20	Монгол Улсын Шадар сайд	8,046.9

	Урсгал зардал	8,046.9
21	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	141,257.7 117,027.1 24,230.6
22	Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	19,337.0 16,928.9 2,408.1
23	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	13,537.0 5,438.5 8,098.5
24	Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	20,051.7 4,380.2 15,671.5
25	Гадаад харилцааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	262,290.7 251,040.3 11,250.4
26	Сангийн сайд Урсгал зардал үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	4,877,188.4 2,791,510.7 1,297,070.7 126,249.3 1,959,428.4
27	Хууль зүй, дотоод хэргийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,725,373.2 1,616,821.3 108,551.9
28	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	48,952.1 27,968.1 20,984.0
29	Батлан хамгаалахын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	819,580.7 744,176.8 75,403.9
30	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	308,571.6 227,741.8 80,829.8
31	Боловсролын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	4,466,080.8 3,993,403.0 472,677.8
32	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	4,495,704.2 4,443,461.9 52,242.3
33	Зам, тээврийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,091,171.8 24,362.8 1,066,809.0
34	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	525,351.8 380,106.1 145,245.7

35	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	424,032.5 69,935.2 354,097.3
36	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	723,002.5 664,422.0 58,580.5
37	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	118,430.3 82,685.2 35,745.1
38	Эрчим хүчний сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	298,411.0 102,217.8 196,193.2
39	Эрүүл мэндийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,847,422.9 1,654,327.4 193,095.6

6.2.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилтийг олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	41,165.2
2	Боловсролын сайд	27,932.7
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	89,831.9
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	4,500.0
5	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	40,985.7

7 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 24,209,847.5 сая төгрөг байна.

8 дугаар зүйл.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 3,124,066.0 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.

9 дүгээр зүйл.“Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд 107,132.1 сая төгрөгийн эргэн төлөлтийг хийнэ.

10 дугаар зүйл.Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 1,596,178.2 сая төгрөг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2025 оны төсвийн жилд 608,889.9 сая төгрөг хуримтлуулна.

11 дүгээр зүйл.2025 оны төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг доор дурдсанаар баталсугай:

11.1.Өрийн удирдлагын тухай хуулийн ³ 12.1.2, 12.1.3-т заасан зориулалтаар хийх дотоод зээллэгийн дээд хэмжээ 300,000.0 сая төгрөг хүртэл;

11.2.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1,542,428.3 сая төгрөг хүртэл.

12 дугаар зүйл.Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2025 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1,669,739.8 сая төгрөг байна.

13 дугаар зүйл.Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2025 оны төсвийн жилд 3,500,000.0 сая төгрөг байна.

14 дүгээр зүйл.Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт ⁴ нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН
НУТГИЙН ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ

15 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэгийг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	46,462.2
2	Баян-Өлгий	29,659.7
3	Баянхонгор	37,765.3
4	Булган	17,895.3
5	Говь-Алтай	29,685.2
6	Дундговь	19,308.7
7	Завхан	47,684.4
8	Өвөрхангай	36,362.0
9	Сүхбаатар	22,417.2
10	Төв	2,154.0
11	Увс	39,573.0

³ Өрийн удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

12	Ховд	14,041.6
13	Хөвсгөл	52,173.4
14	Хэнтий	40,849.4
15	Говьсүмбэр	9,282.0
Нийт дүн		445,313.4

16 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	11,755.7
2	Дорнод	448.0
3	Өмнөговь	1,769,143.3
4	Сэлэнгэ	2,187.4
5	Дархан-Уул	2,981.1
6	Орхон	145,266.8
Нийт дүн		1,931,782.2

17 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг, хот	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	14,505.7
2	Баян-Өлгий	14,026.3
3	Баянхонгор	23,502.4
4	Булган	15,258.1
5	Говь-Алтай	24,990.2
6	Дорноговь	55,686.9
7	Дорнод	30,428.3
8	Дундговь	18,250.4
9	Завхан	17,294.9
10	Өвөрхангай	17,299.9
11	Өмнөговь	60,770.5
12	Сүхбаатар	26,562.7
13	Сэлэнгэ	31,299.0
14	Төв	28,947.2
15	Увс	16,422.8
16	Ховд	30,475.8
17	Хөвсгөл	20,848.6
18	Хэнтий	23,761.1
19	Дархан-Уул	21,288.8
20	Улаанбаатар	60,333.0
21	Орхон	38,727.7
22	Говьсүмбэр	8,374.3

Нийт дүн	599,054.5
----------	-----------

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл.“Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

19 дүгээр зүйл.“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

20 дугаар зүйл.“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

21 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Хөтөлбөр	Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлтийн дугаар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин
1	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА								
	1.1	70101 Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа							
		1.1.1	Хариуцлагатай төр, хүртээмжтэй эдийн засгийг бэхжүүлж, үндэсний өв соёлыг хамгаалахад чиглэсэн бодлого, санаачилгыг дэмжиж ажиллана.	1.1.1.1	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	хувь	2023	100	100
		1.1.2	Үндэсний эв нэгдэл, аюулгүй байдлыг хангаж, хөгжилд хөтлөх гадаад бодлого хэрэгжүүлнэ.	1.1.2.1	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	хувь	2023	100	100
		1.1.3	Нийгмийн хөгжил, ногоон болон хот, хөдөөгийн хөгжлийн бодлогыг дэмжиж ажиллана.	1.1.3.1	Тухай бүрд дэмжиж ажиллах	хувь	2023	100	100
	1.2	70424 Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа							
1.2.1		Төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг улс орны дотоод үйл амьдралын тухай шуурхай мэдээллээр тогтмол хангана. Олон улсын хэмжээнд болж байгаа үйл явдлын мэдээллийг олон нийтэд хүргэнэ. Монгол Улсын дотоод, гадаад бодлого, түүх, өв соёл, уламжлал, хөгжил дэвшлийг гадаад орнуудад эергээр мэдээлж, сурталчлан таниулна.	1.2.1.1	Олон нийтэд зориулан мэдээ мэдээллийг бэлтгэн гаргах	ширхэг	2023	11,765	12,000	
	1.2.1.2		Монгол Улсыг гадаадад сурталчлах мэдээ мэдээллийг бэлтгэн гаргах	ширхэг	2023	10,988	11,208		
2	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА								
	2.1	70102 Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих							

		2.1.1	Хууль, тогтоолын төсөл хэлэлцэж, батална.	2.1.1.1	Байнгын хорооны болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан хууль, тогтоолын төсөл	тоо	2021	521	270 гаруй
		2.1.2	Хууль, тогтоолын биелэлтийг хянан шалгаж, холбогдох тайлан мэдээллийг хэлэлцэж, сонсоно.	2.1.2.1	Хууль тогтоомжийн биелэлттэй танилцах, биелэлтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг, ажлын хэсгийн боловсруулсан санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл	тоо	2021	Ажлын хэсгийн тоо- 36	23
				2.1.2.2	Улсын Их Хурлын гишүүнээс Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад хандан тавьсан асуулга	тоо	2021	Асуулга тавьсан гишүүдийн тоо-41, Асуулгын тоо-23	25
				2.1.2.3	Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагаас хийсэн тайлан, мэдээлэл	тоо	2021	Чуулганы хуралдаан аар хэлэлцүүлсэн мэдээлэл-9	10
				2.1.2.4	Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх	тоо	2021	3	9

				2.1.2.5	Цахим мэдээллийн санд төвлөрүүлсэн хуулийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайлан	тоо	2021	15	25
				2.1.2.6	Улсын Их Хурлын гишүүдийг төсөв, санхүүгийн мэдээллээр хангах	тоо	2021	30	33
				2.1.2.7	Төсвийн төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх болон холбогдох судалгаа шинжилгээ хийх	тоо	2021	4	6
				2.1.2.8	Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хянан шалгах түр хороонд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	тоо	2021	0	3
				2.1.2.9	Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хяналтын сонсгол зохион байгуулах	тоо	2021	0	2
		2.1.3	Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, ажиллах нөхцөлөөр хангана.	2.1.3.1	Хуульд заасны дагуу хангагдсан байх	чанар	2021	Улсын Их Хурлын үйл ажиллагаа нд үзүүлсэн мэргэжил, арга зүй, техник, тоног төхөөрөмж	Улсын Их Хурлын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй ажиллах нөхцөлөөр хангагдсан байна.

3	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА								
	3.1	70404 Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих							
		3.1.1	Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавина.	3.1.1.1	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	хувь	2021	100	90<
				3.1.1.2	Бага суудлын хуралдаанаар гомдол шийдвэрлэлтийн хувь	хувь	2021	100	90<
		3.1.1.3	Дунд, их суудлын хуралдаанаар маргаан хянан шийдвэрлэлтийн хувь	хувь	2021	100	90<		
4	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ								
	4.1	70702 Хяналтын дээд шатны шүүн таслах ажиллагаа							
		4.1.1	Шүүн таслах ажиллагааны чанар, тэгш хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, шударга шүүхээр шуурхай шүүлгэх иргэний эрхийг хангаж, хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацааг бууруулна.	4.1.1.1	Тухайн жилд хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувь	хувь	2023	84.3	94
5	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА								
	5.1	70701 Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах							
		5.1.1	Хэрэг маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэнэ.	5.1.1.1	Хэрэг маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх	хувь	2022	72.9	75.8
6	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА								
	6.1	70714 Сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх							
		6.1.1	Шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой өргөдөл, мэдээллийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн байна.	6.1.1.1	Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл, мэдээллийг шалгаж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь	хувь	2022	96.5	97
7	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА								
	7.1	70409 Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих							
		7.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ.	7.1.1.1	Хүргүүлэх илтгэл	тоо	2023	1	1

		7.1.2	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	7.1.2.1	Гомдол шийдвэрлэлт	хувь	2023	95	96
		7.1.3	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх хяналт шалгалт зохион байгуулна.	7.1.3.1	Хяналт, шалгалт	тоо	2023	120	130
		7.1.4	Комиссын зөвлөмж, гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина.	7.1.4.1	Зөвлөмж, шаардлага	хувь	2023	85	90
		7.1.5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавина.	7.1.5.1	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан	тоо	2023	4	4
		7.1.6	Хүний эрхийн боловсролыг дэмжиж, түгээн дэлгэрүүлнэ.	7.1.6.1	Сургалт	цаг	2023	472	500
		7.1.7	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Улсын Их Хуралд хүргүүлнэ.	7.1.7.1	Тайлан	тоо	2023	1	1
		7.1.8	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай зөвлөмжийн биелэлтийг хангуулна.	7.1.8.1	Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан	тоо	2023	1	1
8	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР								
	8.1	70703 Прокурорын хяналт							
		8.1.1	Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.	8.1.1.1	Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон эрүүгийн хэргийн хяналт, шийдвэрлэлтийн тайлан	тоо	2021	1	1

		8.1.2	Ял эдлүүлэх үйл ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавина.	8.1.2.1	Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон цагдан хорих, баривчлах, саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу шалгалт, судалгаа хийх, танилцах ажиллагаа	тоо	2021	7407	7500
		8.1.3	Монгол Улсын хэмжээнд Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.	8.1.3.1	Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн зөрчлийн тоо	тоо	2021	2,698,521	2,650,000
9	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА								
		70706 Үндэсний аюулгүй байдлыг хангах							
	9.1	9.1.1	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, бодлогын зөвлөгөөгөөр хангах, хяналт тавих, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, гишүүдийн	9.1.1.1	Судалгаанд үндэслэсэн бодлогын зөвлөгөө гаргах	хувь	2022	86	90
				9.1.1.2	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж боловсруулах	хувь	2022	86	90

			хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд үндэсний ашиг сонирхол, оршин тогтнох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засаг, экологийн тэнцвэртэй хөгжлийг хангах, бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх, төрийн болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудад хууль тогтоомж, Зөвлөлийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд нь бодлогын зөвлөгөөгөөр хангах, бодлого боловсруулах, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын салбар хоорондын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.	9.1.1.3	Улс орны хөгжил, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, бодлогын зөвлөгөө гаргах	хувь	2022	100	100
10	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР								
	70402 Төрийн аудитын үйлчилгээ								
	10.1	10.1.1	Баталгаажуулах ажлыг хараат бусаар, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, журам, заавар аргачлалд бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.	10.1.1.1	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах	хувь	2023	100	100
				10.1.1.2	Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийх	хувь	2023	100	100
				10.1.1.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах	хувь	2023	100	100
				10.1.1.4	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг баталгаажуулах	хувь	2023	100	100

				10.1.1.5	Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах	хувь	2023	100	100
				10.1.1.6	Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах	хувь	2023	100	100
				10.1.1.7	Гүйцэтгэх ажилд зориулсан хөрөнгийн зарцуулалтад аудит хийх	хувь	2023	100	100
				10.1.1.8	Бүх шатны төсөв захирагч, тусгай сан, төсөл, хөтөлбөр, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийх	хувь	2023	100	100
		10.1.2	Шууд тайлагнах аудитыг хараат бусаар Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, журам, заавар, аргачлалд бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.	10.1.2.1	Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт /АДБОУС/, Төрийн аудит MNS 6817, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, заавар, аргачлалыг мөрдөж, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны тогтоолд заасан хугацаанд гүйцэтгэж, тайлагнах	хувь	2023	100	100
11	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА								
	70408 Авлигатай тэмцэх								

	11.1	11.1.1	Авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэх хандлагыг төлөвшүүлнэ.	11.1.1.1	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	хувь	2023	75.8	80
		11.1.2	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавина.	11.1.2.1	Мэдүүлгийн бүрдүүлэлт, хянагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/, авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнд холбогдох гомдол, мэдээллийн хяналт шалгалт	тоо	2022	3,700	3,850
		11.1.3	Иргэн, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	11.1.3.1	Өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт	хувь	2023	98	98.2
		11.1.4	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөлийг судлах, эрсдэл тодорхойлох, хяналт тавих ажлыг иргэний нийгэм, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, оролцоог нэмэгдүүлэх ажлыг судалгаанд суурилсан байдлаар төлөвлөн хэрэгжүүлнэ.	11.1.4.1	Сургалтад хамруулсан хүн	тоо	2023	35,573	37,000
				11.1.4.2	Боловсруулсан, орчуулж хэвлүүлсэн ном, гарын авлага	тоо	2023	2	5
				11.1.4.3	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр бүтээсэн контент	тоо	2023	56	58

				11.1.4.4	Улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ	тоо	2023	2	2
				11.1.4.5	Судалгааны тайлан	тоо	2022	3	3
12	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА								
	12.1	70204 Санхүүгийн зах зээлийн зохицуулалт							
		12.1.1	Зохицуулалттай салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.	12.1.1.1	Хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах журмын төсөл	тоо	2023	18	14
		12.1.2	Банкнаас бусад санхүүгийн салбарын эрсдэлийн үнэлгээг сайжруулах тогтолцоог бэхжүүлнэ.	12.1.2.1	Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх	тоо	2023	305	190
		12.1.3	Санхүүгийн зах зээлийн судалгаа, шинжилгээг сайжруулна.	12.1.3.1	Эрдэм шинжилгээ, судалгааны тайлан	тоо	2023	43	10
		12.1.4	Зохицуулалттай салбарын оролцогчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ.	12.1.4.1	Зохицуулалттай салбарын оролцогч	тоо	2023	3639	2450
13	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА								
	13.1	70401 Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт							
		13.1.1	Төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэлийг эрчимжүүлж, сайжруулна.	13.1.1.1	Хууль тогтоомжийн төсөл	тоо	2023	T	1
				13.1.1.2	Дүрэм, журмын төсөл	тоо	2023	T	10
				13.1.1.3	Стандартын төсөл	тоо	2023	T	1
				13.1.1.4	Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт	тоо	2023	800	1,500
				13.1.1.5	Чиг үүргийн шинжилгээ хийхэд төрийн байгууллагад өгсөн мэргэжил, арга зүйн зөвлөгөө	тоо	2023	10	30
		13.1.2	Төрийн албанд сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх, боловсруулах,	13.1.2.1	Сорил, даалгавар, асуулт, хариултын	тоо	2023	1,000	3,000

			монгол хэлний ярианы болон бичгийн өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах хэлбэр, эрх зүйн орчныг шинэчилнэ.		сангийн баяжилтыг чанаржуулах				
				13.1.2.2	Чадварт суурилсан журмыг баталж, мөрдөх шийдвэр	тоо	2023	T	1
				13.1.2.3	Сонгон шалгаруулалт	тоо	2023	1,000	1,500
				13.1.2.4	Цахим системийн хөгжүүлэлт	хувь	2023	40	100
		13.1.3	Хүний нөөцийн аудитын тогтолцоог бүрэн бүрдүүлж, чадахуйн зарчмын хэрэгжилтэд хүний нөөцийн аудит, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	13.1.3.1	Тогтоол, шийдвэр	тоо	2023	T	8
				13.1.3.2	Хүний нөөцийн аудит	тоо	2023	2	8
				13.1.3.3	Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж, тайлан	тоо	2023	T	3
		13.1.4	Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ.	13.1.4.1	Цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн явц	тоо	2023	260/3500	280/4000
				13.1.4.2	Төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	мян.төг	2023	100,000	200,000
		13.1.5	Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурлан ажил үүргийн давхцалыг арилгах, чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, цомхон төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулж, төрийн захиргааны албан хаагчдын тоог үе шаттайгаар зохистой хэмжээнд хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.	13.1.5.1	Бодлогын санал	тоо	2023	T	1
				13.1.5.2	Судалгааны ажил	тоо	2023	T	1
		13.1.6	Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, цахим мэдээллийг албан хаагчдад нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, цахим системийн аюулгүй байдлыг хангаж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангана.	13.1.6.1	Системийн модуль хөгжүүлэлт, нэвтрүүлэлт	хувь	2023	40	90
				13.1.6.2	Цахим мэдээлэлд нээлттэй хандах албан хаагч	тоо	2023	T	227,0
				13.1.6.3	Мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдал	хувь	2023	60	100

				13.1.6.4	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ	тоо	2023	T	1
				13.1.6.5	Цахим системийн хатуу дэд бүтцийн шинэчлэлт	хувь	2023	T	100
		13.1.7	Төрийн албан хаагчийн сургалтын бодлого, чиглэлд шинэчлэл хийх, тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	13.1.7.1	Сургалтын тоо	тоо	2023	10	20
				13.1.7.2	Гадаад улсын сургалтад хамрагдсан албан хаагч	тоо	2023	T	20
				13.1.7.3	Дотоодын сургалтад хамрагдсан албан хаагч	тоо	2023	40,000	80,000.0<
				13.1.7.4	Хувийн хэвшлийн оролцоо	тоо	2023	T	2
		13.1.8	Төрийн албаны судалгааны нэгдмэл, уялдаатай байдлыг хангаж, үр дүнг үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.	13.1.8.1	Судалгааны дүгнэлт, тайлан	тоо	2023	T	3
		13.1.9	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.	13.1.9.1	Дүрэм, журмын төсөл	тоо	2023	T	1
				13.1.9.2	Зөвлөмж, шийдвэр	тоо	2023	T	1
		13.1.10	Ёс зүйн хороонд ирсэн гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	13.1.10.1	Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт	хувь	2024	T	85
				13.1.10.2	Сургалт, нөлөөллийн аян	тоо	2024	18	20
				13.1.10.3	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц	хэрэгжилтийн биелэлт	2024	T	25
				13.1.10.4	Цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн явц	хувь	2024	70	90

			цахим системийн хөгжүүлэлтийг хийнэ.						
14	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА								
	14.1	70405 Албан ёсны статистик							
		14.1.1	Статистикийн тухай хуульд заасны дагуу Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтаар албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг гаргасан байна.	14.1.1.1	Захиргааны статистикийн мэдээлэл, тайлангийн нэр, төрөл	тоо	2024	211	403
				14.1.1.2	Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтсээс ирүүлдэг мэдээ, тайлан	тоо	2024	53	55
		14.1.2	Статистикийн тухай хуульд заасны дагуу бодлого боловсруулагчид, хэрэглэгчдийг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгаар сар бүр, статистикийн эмхэтгэлийг жилээр бэлтгэж, тархаасан байна.	14.1.2.1	Монгол Улсын статистикийн эмхэтгэл	тоо	2024	1	1
				14.1.2.2	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сарын бюллетень, танилцуулга	тоо	2024	36	36
		14.1.3	Статистикийн мэдээллийн нэгдсэн санг 7 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар баяжуулж, хуульд заасан давтамжтай тооллого, судалгааны үр дүнг тухай бүрд нийтэд тархаасан байна.	14.1.3.1	Инфографик танилцуулга	тоо	2024	20	20
				14.1.3.2	Тооллого, судалгааны үр дүн	тоо	2024	6	10
				14.1.3.3	Мэдээллийн нэгдсэн сангийн тайлан /1212.мн/	тоо	2024	845	850
		14.1.4	Статистикийн мэдээллийн арга зүй, аргачлалыг илүү боловсронгуй болгох, сайжруулах үүднээс холбогдох салбарын үзүүлэлтийн аргачлалыг шинэчлэн боловсронгуй болгоно.	14.1.4.1	Шинээр боловсруулах болон шинэчлэх аргачлал, ангиллын тоо	тоо	2024	9	6
		14.1.5	Статистикийн мэдээллийн санд үндэслэн нийгэм, эдийн засгийн салбаруудын жилийн дэлгэрэнгүй танилцуулга, тооллого, судалгааны үр дүнг боловсруулж, тархаасан байна.	14.1.5.1	Статистикийн мэдээллийн санд суурилж, нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгааны тоо	тоо	2024	33	35
		14.1.6	Статистикийн тухай хуульд заасан Мал, тэжээвэр амьтад, хашаа,	14.1.6.1	Тооллого	тоо	2024	2	2

			худгийн тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгаа, Ардчилал засаглал судалгаа, Цаг ашиглалтын судалгаа, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, Гэмт хэргийн хохирогчийн судалгаа зэрэг тооллого, судалгааг зохион байгуулж, явуулсан байна.	14.1.6.2	Судалгаа	тоо	2024	6	3
15	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА								
	15.1	70403 Бүх шатны сонгууль зохион байгуулах							
		15.1.1	Сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгогчийн оролцоог нэмэгдүүлнэ.	15.1.1.1	Сонгогчийн боловсролыг дээшлүүлэх	багц материал ын тоо	2024	4	4
						сургалтын тоо	-	-	4
		15.1.2	Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд оролцогчийн чадавхыг сайжруулна.	15.1.2.1	Байнгын ажиллагаатай бус сонгуулийн байгууллагад ажиллах төрийн албан хаагч болон даамалд зориулсан сургалт	сургалтын тоо	2023	18	18
		15.1.3	Улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгоно.	15.1.3.1	Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланг ил тод болгох, чадавхжуулах	тайлангийн тоо	-	-	7
				15.1.3.2	Улс төрийн намын мэдээллийн сан үүсгэх, нээлттэй болгох	сургалтын тоо	-	-	7
		15.1.4	Мэдээллийн сан үүсгэх, аюулгүйн болон бэлэн байдлыг хангана.	15.1.4.1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн мэдээллийн сан үүсгэх	мэдээлэл	2023	14	14

				15.1.4.2	Тоног төхөөрөмжийн аюулгүйн болон бэлэн байдлыг хангах	тоног төхөөрөмжийн тоо	2024	3000	3000
16	ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА								
	16.1	72204 Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах үйл ажиллагаа							
		16.1.1	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангуулж, Тагнуулын ерөнхий газрын тусгай архивт хадгалагдаж байгаа хэрэг, хөдөө орон нутгийн архивуудаас татан төвлөрүүлсэн хэрэг, өмнө нь шалгаад нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагааг зогсоосон хэргүүдийг зөвлөмжийн дагуу шалгаж эцэслэн шийдвэрлэнэ.	16.1.1.1	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг олж тогтоох зорилгоор шалгах хэрэг, материалын тоо	тоо	2023	269	240
		16.1.2	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчид шүүхийн шийдвэрийг үндэслэн нөхөх олговор олгоход дэмжлэг үзүүлнэ.	16.1.2.1	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан нэхэмжлэгчдэд шүүхийн шийдвэрийн дагуу нөхөх олговор олгох	тоо	2023	5	10
				16.1.2.2	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан нэхэмжлэгчдэд олгох нөхөх олговор	тоо	2023	314	8

		16.1.3	Соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, хэлмэгдүүлэлт давтагдахаас урьдчилан сэргийлнэ.	16.1.3.1	Хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан Ногоон төглийг 10 аймагт бий болгож хаягжуулах	тоо	2023	10	10
				16.1.3.2	Хуулийн хэрэгжилтийг олон нийт, иргэд, залуучуудад сурталчлах зорилгоор телевиз, радио, сонин, цахим хуудас эрхлэгчтэй хамтран ажиллах, /Хамаг монгол бүү мартагтун/ төслийг дуусгах	хувь	2023	90	100
17	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД								
	17.1	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх							
		17.1.1	Төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	17.1.1.1	Төрийн өмчит компанийн засаглалын үнэлгээ	хувь	2021	53.9	80
				17.1.1.2	Олон нийтийн шууд хяналтад оруулсан төрийн өмчит компани	тоо	2021	1	2
		17.1.2	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.	17.1.2.1	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох	хувь	2021	40	90
				17.1.2.2	Улсын үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилт	хувь	2021	97	100
		17.1.3	Төрийн өмчид тавих төрийн хяналт сайжирч, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.	17.1.3.1	Төрийн өмчийн хяналт, шалгалт	тоо	2021	38	35
				17.1.3.2	Хууль, эрх зүйн шинэчлэлт	хувь	2021	70	90
		17.2	72201 Жендэрийн тэгш байдлыг хангах						

		17.2.1	Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.	17.2.1.1	Тухайн жилийн сургалт, сургагч багш, сургалтад хамрагдсан удирдах ажилтан /УА/, төрийн албан хаагчийн тоо /ТАХ/, салбар, орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт	хамрагдсан УА, ТАХ-ийн тоо	2021	Сургагч багш-154, УА-65, ТАХ-65	Сургагч багш-304, УА-80, ТАХ-85
		17.2.2	Яамдын жендэрийн бодлого болон аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.	17.2.2.1	Орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээрх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	төлөвлөгөөний тоо	2021	30	31
				17.2.2.2	Орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтэд оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр салбар хороонд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	хороодын тоо	2021	9	21
		17.2.3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна.	17.2.3.1	Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй редакцын бодлогыг бодитоор хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах	сургалтын тоо	2021	5	13

				17.2.3.2	Сэтгүүлч, нийгмийн ажилтан, эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулийн хөтөлбөрт жендэрийн хөтөлбөр тусгасан сургуулийн тоо	тоо	2024	32	40
		17.2.4	Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллын сүлжээг өргөжүүлж, жендэрийн тэгш байдлын талаар улс төрийн нам, олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлнэ.	17.2.4.1	Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачилгыг дэмжиж ажиллах	хөтөл бөр	-	-	1
				17.2.4.2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн сайн туршлагын талаарх сурталчилгаа	тоо	2021	3	7
		17.2.5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангаж түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна.	17.2.5.1	Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг шинэчлэн боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ	тоо	2023	T	2
				17.2.5.2	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх илтгэх хуудас	тоо	2024	1	1
		71504 Газрын зураглал, кадастр							
	17.3	17.3.1	Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа 38 хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	17.3.1.1	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ	хувь	2023	100	100

		17.3.2	GNSS-ийн суурин станцын тоог 10-аар нэмэгдүүлнэ.	17.3.2.1	Монгол Улсын GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээг өтгөрүүлэх	хувь	2023	43	61
		17.3.3	Нийслэл, 21 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалах, хуваарилах дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгээр бүрэн хангасан байна.	17.3.3.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх /Увс, Дундговь, Завхан/	тоо	2023	15	22
		17.3.4	Геопорталын хөгжүүлэлт хийгдэж орон зайн суурь 18 дэд сангийн мэдээллийг агуулсан сэдэвчилсэн зургийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	17.3.4.1	Геоорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын “нэг газрын зураг”, иргэн, олон нийт, бизнесийн зориулалттай “нээлттэй газрын зураг” цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх	хандалт	2023	1,919,066	3,450,000
		17.3.5	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа бүрэн цахимжсан байна.	17.3.5.1	Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох	хувь	2023	50	100

		17.3.6	Монгол Улсын аймаг, сумын төвийг 1:1000-ны масштабтай байр зүйн зургаар хангасан байна.	17.3.6.1	Улсын хэмжээнд хот, суурин газрын төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх	хувь	2024	95	100
		17.3.7	Газар зүйн орон зайн мэдээллийг нээлттэй болгож, эдийн засгийн өсөлтийг бий болгоно.	17.3.7.1	Хиймэл оюун ухаан, блокчэйн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх /Улсын хэмжээнд/	хувь	2024	10	12
18	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД								
	18.1	70201 Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт							
		18.1.1	Дунд, богино хугацааны хөгжлийн бодлого тодорхой болсон байна.	18.1.1.1	Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах	тоо	2023	1	2
		18.1.2	Макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах төсвийн бодлогын чиглэл, эдийн засгийн хэт халалт, уналтын эсрэг бодлого оновчтой тодорхойлогдсон байна.	18.1.2.1	Эрх зүйн баримт бичиг	тоо	2024	1	1
	18.2	70428 Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт							

		18.2.1	Оюуны өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.	18.2.1.1	Оюуны өмчийн бүтээлийн сан бүрдүүлэлт /аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн гэрээ, хэлэлцээрийн баталгаажилт/	ширхэг	2021	4200	4200
				18.2.1.2	Оюуны өмчийн талаарх мэдээлэл, сургалт хийх, лавлагаа гаргах	ширхэг	2021	70	70
				18.2.1.3	Оюуны өмчийн зөрчилд хяналт тавьж шийдвэрлэх	ширхэг	2021	450	450
	18.3	71805 Шинжлэх ухаан, технологи							
		18.3.1	Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэн байна.	18.3.1.1	Судалгаа боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	тоо	2023	1550	1600
				18.3.1.2	Эрдэм шинжилгээ, судалгааны менежментийг боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	тоо	2023	12610	13000
	18.3.1.3			Шинжлэх ухаан, технологийн үр дүн, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх	тоо	2023	16	25	
	19	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД							
		19.1	70708 Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх						
			19.1.1	Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг нэмэгдүүлнэ.	19.1.1.1	Шинээр байгуулагдах анги, салбар, нэгж	тоо	2021	-

				19.1.1.2	Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж	тоо	2021	57	59
				19.1.1.3	Гамшгийн үед ашиглах орчин үеийн дэвшилтэт технологи	тоо	2021	-	30
19.2	70201 Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт								
	19.2.1	Бүс, орон нутгийн хөгжлийг нэмэгдүүлнэ.	19.2.1.1	Орон нутгийн хөгжлийн индекс	оноо	2021	0.532	0.581	
